

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

“Инновэйшн Инвестмент” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж-19 хаягт байрлах Шангри-Ла зочид буудлын Баллрүүм хурлын танхимд болон цахим хэлбэрээр эхлэв.

Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Даваа даргалав.
Хурлын ирц: 96.92%

ХУРАЛД ОРОЛЦСОН:

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

- Бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргасан нийт хувьцаа эзэмшигчдээс 46 хувьцаа эзэмшигч хуралд биечлэн болон <https://www.investmentexpo.mn/> цахим хуудсыг ашиглан цахимаар оролцсон.

Бусад:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Даваа;
- Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх;
- Тооллогын комисс

Хурлын тэмдэглэлийг Т.Отгон хөтлөв.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
- Компанийн хэлбэр өөрчлөх, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай;
- ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох тухай.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Г.Эрдэнэмөнх: “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр нээлттэй компани болсны дараах анхдугаар хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж дүрмийг шинэчлэн батлан хувьцаат компаниар улсын бүртгэлд бүртгүүлэн дараа дараагийн үйл ажиллагааг Хувьцаат компанийн нэр дор явуулах онцгой хурал болж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг танилцуулав.

Хурлын Д.Давааг хурлыг нээнэ үү хэмээн урьж байна.

Д.Даваа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Крау үйлчилгээ нээгдээд 8 жилийн нүүрийг үзэж байна. Өнөөдөр Хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурлыг нээж байгааг үүгээр

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

мэдэгдье. Компани маань цаашдаа илүү олон үйлчилгээнүүдийг нэвтрүүлж хувьцаа эзэмшигч та бүхэнд илүү өндөр үр дүнг хүргэнэ гэдэгт итгэлтэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хуралд та бүхнийг идэвхитэй оролцоно гэж найдаж байна.

Г.Эрдэнэмөнх: Тооллогын комиссын дарга Г.Бат-Эрдэнэ хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг танилцуулна уу хэмээн урьж байна.

Тооллогын комиссын дарга Г.Бат-эрдэнэ тооллогын комиссын гишүүдийн танилцуулга, хурлын ирцийг танилцуулав.

Г.Бат-эрдэнэ: “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 28-ны Хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хуралдаанаар 170,686,374 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 177,017,618.00 ширхэг энгийн хувьцааны 96.48% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлж байна.

Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт болон “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 96.48%-ийг эзэмшигч саналын хуудсаар санал ирүүлсэн тул компанийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож байна.

Г.Эрдэнэмөнх: Тооллогын комиссын дарга Г.Бат-Эрдэнэд баярлалаа. Хурлын ирц бүрдсэн тул Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг миний бие танилцуулья.

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав.

Хурлын дарга Д.Даваа хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулна.

Д.Даваа: 2023 оны хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулья.

Компанийн 2023 оны хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулав.

Г.Эрдэнэмөнх: Та бүхнээс эхний асуудалд саналаа өгнө үү гэж хүсэж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчид санал өгөв.

Г.Эрдэнэмөнх: Бидний хэлэлцэх хоёрдугаар асуудал бол Компанийн хэлбэр өөрчлөх, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай асуудал байна. Компанийн хэлбэр өөрчлөх, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах шаардлагатай байна. Учир нь IPO хийж нээлттэй ХК болсон тул компанийн хэлбэрийг өөрчлөх шаардлагатай.

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулав.

Та бүхнээс хоёрдугаар асуудалд саналаа өгнө үү гэж хүсэж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчид санал өгөв.

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Г.Эрдэнэмөнх: Бидний хэлэлцэх гуравдугаар асуудал бол ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох тухай асуудал байна. Компанийн хэлбэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн гишүүдийг дахин сонгох шаардлагатай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн мэдээллийг танилцуулав.

Г.Эрдэнэмөнх: Хувьцаа эзэмшигч нарт асуулт байна уу?

Компанийн хувьцаа эзэмшигчид байхгүй гэв.

Та бүхнээс гуравдугаар асуудалд саналаа өгнө үү гэж хүсэж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчид санал өгөв.

Тооллогын комисс саналын хуудсыг хүлээн авав.

Тооллогын комисс санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулав.

Г.Бат-Эрдэнэ: “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хувьцаа эзэмшигч нарт мэдээлсүгэй. Үүнд:

“Инновэйшн Инвестмент” ХХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 28-ны Хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хуралдаанд санал хураах үеийн эцсийн байдлаар 171,577,833 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 177,017,618.00 ширхэг энгийн хувьцааны 96.92% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлж байна.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

- 1.1. **Инновэйшн Инвестментийн Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай** асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 167,983,598 ширхэг хувьцаа буюу 97.91% зөвшөөрсөн, 0 ширхэг хувьцаа буюу 0% татгалзсан, 0 ширхэг хувьцаа буюу 0% түдгэлзсэн, 3,594,235 ширхэг хувьцаа буюу 2.09% хоосон саналтай байх тул энэхүү асуудал дэмжигдсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
167,983,598	97.91%%	0	0%	0	0%

- 1.2. **Компанийн хэлбэр өөрчлөх, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай** асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй нийт хувьцаа

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

эзэмшигчдийн 167,983,598 ширхэг хувьцаа буюу 97.91% зөвшөөрсөн, 0 ширхэг хувьцаа буюу 0% татгалзсан, 0 ширхэг хувьцаа буюу 0% түдгэлзсэн, 3,594,235 ширхэг хувьцаа буюу 2.09% хоосон саналтай байх тул энэхүү асуудал дэмжигдсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
167,983,598	97.91%%	0	0%	0	0%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

1.3. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 97.91% буюу 167,986,574.00 ширхэг хувьцаатай 33 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн санал дараах байдалтай байна. Үүнд:

а. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн бус гишүүнд нэр дэвшигч:

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Кумулятив аргаар өгсөн саналын тоо	Хувь
1.	Б.Анхболд	189,482,711.00	12.53%
2.	А.Баттамир	73,505,025.00	4.86%
3.	Б.Чулуунсүх	186,726,511.00	12.35%
4.	Д.Даваа	3,747,120.00	0.25%
5.	Г.Хатанболд	73,087,303.00	4.83%
6.	У.Мөнхзул	167,401,249.00	11.07%
7.	У.Наранбаатар	181,098,982.00	11.98%

б. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч:

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Кумулятив аргаар өгсөн саналын тоо	Хувь
1.	Б.Батсолонго	1,000,107.00	0.07%
2.	Б.Нандин-Эрдэнэ	103,720,642.00	6.86%
3.	Д.Ганзориг	208,060,330.00	13.76%
4.	П.Болормаа	2,949.00	0.00%
5.	Т.Дашцэрэн	207,291,364.00	13.71%
6.	А.Тамир	2,365.00	0.00%
7.	С.Хулан	1,142.00	0.00%
8.	Д.Ганбаяр	5.00	0.00%
9.	Г.Энх-Амгалан	5.00	0.00%
10.	С.Насанжаргал	30,005.00	0.00%
11.	Ц.Бахархал	5.00	0.00%
12.	М.Оюунтөгс	1,038.00	0.00%
13.	Ш.Уянга	116,714,091.00	7.72%
14.	Д.Гантуул	6.00	0.00%
15.	Д.Энхжаргал	5,003.00	0.00%
16.	З.Хайдар	2.00	0.00%

тус тус санал авсан.

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Г.Эрдэнэмөнх: Тооллогын комиссын тайлан мэдээтэй танилцлаа. Хурлан дарга Д.Давааг хурлын шийдвэр, компаниас гарах тогтоолын төслүүдийг танилцуулахыг хүсэж байна.

Д.Даваа: Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг танилцуулья.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг танилцуулав.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал амжилттай зохион байгуулагдаж холбогдох тогтоолуудыг баталлаа. Компанийн цаашдын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Хурал 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:07 цагт дуусав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Дараах асуудлыг шийдвэрлэж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол гаргав.

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухайд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийн дагуу энэхүү тогтоолын Хавсралт№1-т заасны дагуу Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг, Хавсралт№2-т заасны дагуу Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталсугай.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, аудитын дүгнэлтийн хамт тус тус Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/- д үүрэг болгосугай.

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухайд:

1. Компани нь 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 551 тоот тогтоолоор үнэт цаасаа бүртгүүлж, хувьцаагаа нийтэд санал болгон худалдах ажиллагааг амжилттай хэрэгжүүлсн болохыг дурьдсугай.
2. Үүнтэй холбогдуулан, компанийн хэлбэрийг “Инновэйшн инвестмент” ХК болгон өөрчлөхөөр шийдвэрлэсүгэй.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Компанийн дүрмийг Хавсралт №1-ийн дагуу шинэчлэн баталсугай.
4. Компанийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, баримт бичиг хүргэх, хүлээн авах эрхийг С.Гүржав /РД: ТБ81112013/-д итгэмжлэн олгосугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, шинээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн томилох тухайд:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах хүмүүсийг томилсугай:

1.1. Б.Анхболдыг ТУЗ-ийн гишүүнээр;

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

- 1.2. Б.Чулуунсүхийг -ТУЗ-ийн гишүүнээр;
 - 1.3. У.Наранбаатарыг -ТУЗ-ийн гишүүнээр;
 - 1.4. У.Мөнхзулыг -ТУЗ-ийн гишүүнээр;
 - 1.5. А.Баттамирыг -ТУЗ-ийн гишүүнээр;
 - 1.6. Г.Хатанболдыг -ТУЗ-ийн гишүүнээр;
 - 1.7. Д.Ганзоригийг -ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
 - 1.8. Т.Дашцэрэнг -ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
 - 1.9. Ш.Уянгыг -ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж болон улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмох/-д үүрэг болгосугай.
5. Төлөөлөн удирдах зөвлөл томилогдсонтой холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаа сонгох, компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд үр ашигтай бөгөөд зохистойгоор удирдан явуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



/Д.ДАВАА/

/Т.ОТГОН/